



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/97/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn  
Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж  
Утас: 77721628  
Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangaiaudit@gov.mn

2026. 02. 24 № 58  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
5 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Д.МӨНХЖАРГАЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,685,145.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 3,407,011.0 мянган төгрөг зарцуулсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 19 үндсэн зорилтын хүрээнд 115 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>436,766,558.12</b>	<b>342,238,237.65</b>
31	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>295,547,641.68</b>	<b>185,190,144.75</b>
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>295,547,641.68</b>	<b>185,190,144.75</b>
3121	<b>Төгрөг</b>	<b>295,547,641.68</b>	<b>185,190,144.75</b>
31211	Төрийн сангийн харилцах	295,547,641.68	185,190,144.75
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>340,550.00</b>	<b>0.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	340,550.00	0.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>140,878,366.44</b>	<b>157,048,092.90</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>112,015,266.44</b>	<b>106,473,732.90</b>
35110	Тусгай зориулалттай материал	109,378,857.35	103,837,323.81
35130	Эм боох материал	2,636,409.09	2,636,409.09
354	<b>Хангамжийн материал</b>	<b>28,863,100.00</b>	<b>50,574,360.00</b>
35420	Аж ахуйн материал	28,863,100.00	50,574,360.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,013,206,403.73</b>	<b>4,068,773,084.70</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,013,206,403.73</b>	<b>4,068,773,084.70</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,834,696,403.73</b>	<b>3,890,263,084.70</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,078,516,587.67	4,225,333,287.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	(536,120,365.88)	(626,630,021.64)
39203	Авто тээврийн хэрэгсэл	36,600,000.00	36,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,399,999.84)	(30,499,999.80)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	247,370,800.42	286,766,650.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(122,518,240.40)	(156,725,185.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	283,145,309.60	319,426,087.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(168,550,187.74)	(200,790,636.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,117,436.80	46,117,436.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,478,387.20)	(19,347,984.00)
39217	Ном	10,013,450.30	10,013,450.30
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>178,510,000.00</b>	<b>178,510,000.00</b>
39301	Програм хангамж	1,699,500.00	1,699,500.00
39302	Хасагдуулга	(1,699,500.00)	(1,699,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	178,510,000.00	178,510,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,449,972,961.85</b>	<b>4,411,011,322.35</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>4,258,320.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>4,258,320.00</b>
413	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>4,258,320.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>4,258,320.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	4,258,320.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,449,972,961.85</b>	<b>4,406,753,002.35</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,449,972,961.85</b>	<b>4,406,753,002.35</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	178,510,000.00	178,510,000.00
51101	Өмч: - төрийн	178,510,000.00	178,510,000.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,974,441,270.20</b>	<b>3,931,221,310.70</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	3,974,441,270.20	3,974,441,270.20
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(43,219,959.50)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297,021,691.65	297,021,691.65
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,449,972,961.85</b>	<b>4,411,011,322.35</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,082,627,881.60</b>	<b>3,541,301,558.24</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>54,467,581.60</b>	<b>204,453,658.24</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>54,467,581.60</b>	<b>204,453,658.24</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>10,874,000.00</b>	<b>13,581,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,049,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,825,000.00	13,581,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	31,645,050.00	170,549,327.78
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	11,948,531.60	20,323,230.46
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,028,160,300.00</b>	<b>3,336,847,900.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,651,542,200.00</b>	<b>2,924,685,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,651,542,200.00	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	2,924,685,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,548,100.00</b>	-
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,548,100.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>373,070,000.00</b>	<b>412,162,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	373,070,000.00	412,162,400.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,999,399,750.85</b>	<b>3,584,521,517.74</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,999,399,750.85</b>	<b>3,584,521,517.74</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,873,573,382.14</b>	<b>3,380,442,547.44</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,851,048,555.53</b>	<b>2,253,129,666.23</b>
210101	Цалин	1,234,176,980.17	1,386,337,860.99
210102	Нэмэгдэл цалин	480,505,292.07	657,467,337.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	56,415,000.00
210104	Урамшуулал	136,366,283.29	152,909,467.38
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>233,511,932.14</b>	<b>284,657,580.70</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	162,090,331.35	194,556,198.42
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	18,670,388.56	22,840,493.83
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,310,437.69	11,800,938.32
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	8,589,596.12	11,326,252.11
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	34,851,178.42	44,133,698.02
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>348,132,907.49</b>	<b>346,386,919.70</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	23,837,666.00	29,696,638.00
210302	Түлш, халаалтын зардал	277,014,000.00	277,014,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	47,281,241.49	39,676,281.70
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,398,524.00</b>	<b>30,254,000.00</b>
210401	Бичиг хэргийн материал	1,547,100.00	1,156,150.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,350,000.00	1,900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,501,424.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	27,197,850.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>130,525,714.40</b>	<b>174,176,898.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	235,280.00	270,776.00
210502	Хоол, хүнс	130,290,434.40	173,906,122.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,820,000.00</b>	<b>11,999,260.00</b>
210604	Урсгал засвар	9,820,000.00	11,999,260.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>13,750,641.63</b>	<b>20,260,659.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,871,321.63	-

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	7,879,320.00	20,260,659.60
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>267,385,106.95</b>	<b>259,577,563.21</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,944,182.20	76,153,102.40
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	24,384,510.00	16,497,814.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	177,056,414.75	166,926,646.81
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>125,826,368.71</b>	<b>204,078,970.30</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>110,889,276.20</b>	<b>150,303,490.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,606,776.20	107,421,990.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,282,500.00	42,881,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,937,092.51</b>	<b>53,775,480.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,937,092.51	53,775,480.30
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>83,228,130.75</b>	<b>(43,219,959.50)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>15,392,720.50</b>	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,392,720.50	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>15,392,720.50</b>	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>67,835,410.25</b>	<b>(43,219,959.50)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	3,039,034,300.00	3,350,429,000.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	10,874,000.00	13,581,100.00
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,874,000.00	13,581,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,874,000.00	13,581,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,049,000.00	13,581,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,825,000.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	3,028,160,300.00	3,336,847,900.00
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,651,542,200.00	2,924,685,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,651,542,200.00	2,924,685,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,548,100.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,548,100.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	373,070,000.00	412,162,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	373,070,000.00	412,162,400.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	2,822,762,294.50	3,408,842,496.93
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,822,762,294.50	3,408,842,496.93
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,695,552,475.79	3,206,416,716.63
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,851,389,105.53	2,252,789,116.23
210101	Үндсэн цалин	1,171,303,828.93	1,385,997,310.99
210102	Нэмэгдэл	543,759,323.40	657,467,337.86
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	56,415,000.00
210104	Урамшуулал	136,325,953.20	152,909,467.38
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	233,511,932.14	284,657,580.70
210201	Тэтгэврийн даатгал	162,090,331.35	194,556,198.42
210202	Тэтгэмжийн даатгал	18,670,388.56	22,840,493.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,310,437.69	11,800,938.32
210204	Ажилгүйдлийн даатгал	8,589,596.12	11,326,252.11
210205	Эрүүл мэндийн даатгал	34,851,178.42	44,133,698.02
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	348,132,907.49	346,386,919.70
210301	Гэрэл, цахилгаан	23,837,666.00	29,696,638.00
210302	Түлш, халаалт	277,014,000.00	277,014,000.00
210303	Цэвэр, бохир ус	47,281,241.49	39,676,281.70
2105	<b>Нормативт зардал</b>	129,331,530.00	172,316,600.00
210502	Хоол, хүнс	129,331,530.00	172,316,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	12,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,262,250.63	40,559,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,049,000.00	2,036,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,213,250.63	38,522,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	88,924,750.00	97,707,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,652,250.00	82,641,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,272,500.00	15,066,200.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	127,209,818.71	202,425,780.30
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	112,272,726.20	148,650,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72,990,226.20	105,768,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,282,500.00	42,881,500.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,937,092.51	53,775,480.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,937,092.51	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	14,937,092.51	53,775,480.30
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	216,272,005.50	(58,413,496.93)
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	71,986,550.00	51,944,000.00

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	Дотоод эх үүсвэрээр	71,986,550.00	51,944,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,986,550.00	51,944,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(71,986,550.00)	(51,944,000.00)
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	144,285,455.50	(110,357,496.93)
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	151,262,186.18	295,547,641.68
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	295,547,641.68	185,190,144.75

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	178,510,000.00	297,021,691.65	3,906,605,859.95	4,382,137,551.60
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	178,510,000.00	297,021,691.65	3,906,605,859.95	4,382,137,551.60
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	67,835,410.25	67,835,410.25
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	178,510,000.00	297,021,691.65	3,974,441,270.20	4,449,972,961.85
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	178,510,000.00	297,021,691.65	3,974,441,270.20	4,449,972,961.85
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,219,959.50)	(43,219,959.50)
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	178,510,000.00	297,021,691.65	3,931,221,310.70	4,406,753,002.35

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

( төгрөгөөр )

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>3,683,983,500.00</b>	<b>3,407,011,016.63</b>	<b>276,972,483.37</b>	<b>92.48</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>3,683,983,500.00</b>	<b>3,407,011,016.63</b>	<b>276,972,483.37</b>	<b>92.48</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>3,531,834,600.00</b>	<b>3,258,360,716.63</b>	<b>273,473,883.37</b>	<b>92.26</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2101	2,446,988,000.00	2,252,789,116.23	194,198,883.77	92.06
Үндсэн цалин	210101	1,543,609,100.00	1,385,997,310.99	157,611,789.01	89.79
Нэмэгдэл	210102	793,824,700.00	657,467,337.86	136,357,362.14	82.82
Унаа хоолны Хөнгөлөлт	210103	-	56,415,000.00	(56,415,000.00)	-
Урамшуулал	210104	109,554,200.00	152,909,467.38	(43,355,267.38)	139.57
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2102	<b>306,018,600.00</b>	<b>284,657,580.70</b>	<b>21,361,019.30</b>	<b>93.02</b>
Тэтгэврийн даатгал	210201	208,092,700.00	194,556,198.42	13,536,501.58	93.49
Тэтгэмжийн даатгал	210202	24,481,500.00	22,840,493.83	1,641,006.17	93.30
ҮОМШӨ-ний даатгал	210203	12,240,700.00	11,800,938.32	439,761.68	96.41
Ажилгүйдлийн даатгал	210204	12,240,700.00	11,326,252.11	914,447.89	92.53
Эрүүл мэндийн даатгал	210205	48,963,000.00	44,133,698.02	4,829,301.98	90.14
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2103	<b>401,962,400.00</b>	<b>346,386,919.70</b>	<b>55,575,480.30</b>	<b>86.17</b>
Гэрэл, цахилгаан	210301	52,527,200.00	29,696,638.00	22,830,562.00	56.54
Түлш, халаалт	210302	277,014,000.00	277,014,000.00	-	100.00
Цэвэр, бохир ус	210303	72,421,200.00	39,676,281.70	32,744,918.30	54.79
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2104	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нормативт зардал</b>	2105	<b>172,316,600.00</b>	<b>172,316,600.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
Хоол, хүнс	210502	172,316,600.00	172,316,600.00	-	100.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2106	<b>12,000,000.00</b>	<b>12,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
Урсгал засвар	210604	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
<b>Томилголт, зочны зардал</b>	2107	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2108	<b>41,266,600.00</b>	<b>40,559,000.00</b>	<b>707,600.00</b>	<b>98.29</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210801	2,036,400.00	2,036,400.00	-	100.00

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	39,230,200.00	38,522,600.00	707,600.00	98.20
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2109	<b>151,282,400.00</b>	<b>149,651,500.00</b>	<b>1,630,900.00</b>	<b>98.92</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	136,216,200.00	134,585,300.00	1,630,900.00	98.80
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	15,066,200.00	15,066,200.00	-	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>152,148,900.00</b>	<b>148,650,300.00</b>	<b>3,498,600.00</b>	<b>97.70</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	-	-
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	213	<b>152,148,900.00</b>	<b>148,650,300.00</b>	<b>3,498,600.00</b>	<b>97.70</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213209	42,881,500.00	42,881,500.00	-	100.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>3,683,983,500.00</b>	<b>3,296,653,519.70</b>	<b>388,788,680.30</b>	<b>89.49</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	131	<b>3,257,898,700.00</b>	<b>2,924,685,500.00</b>	<b>333,213,200.00</b>	<b>89.77</b>
Улсын төсвөөс санхүүжих	131001	2,973,664,700.00	2,924,685,500.00	48,979,200.00	98.35
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	284,234,000.00	-	284,234,000.00	-
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>413,962,400.00</b>	<b>358,386,919.70</b>	<b>55,575,480.30</b>	<b>86.57</b>
Орон нутгийн төсвөөс	132001	413,962,400.00	358,386,919.70	55,575,480.30	86.57
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		<b>12,122,400.00</b>	<b>13,581,100.00</b>	-	<b>112.03</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	12,122,400.00	13,581,100.00	(1,458,700.00)	112.03
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>295,547,641.68</b>	<b>295,547,641.68</b>	-	<b>100.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>295,547,641.68</b>	<b>185,190,144.75</b>	<b>111,816,196.93</b>	<b>62.66</b>
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
БАЙГУУЛЛАГЫН ТОО		1.00	1.00	-	100.0%
Төсвийн байгууллага		1.00	1.00	-	100.0%
АЖИЛЛАГСАДЫН ТОО		86.00	78.00	8.00	90.7%
Удирдах ажилтан		4.00	4.00	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан		54.00	46.00	8.00	85.2%
Үйлчлэх ажилтан		28.00	28.00	-	100.0%
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		767.00	767.00	-	100.0%
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД		767.00	767.00	-	100.0%

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 24,400.1 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 12,590.1 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 11,809.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 6 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 24,400.1 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 39,743.6 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Нэр бүхий 36 ажилтныг захирлын тушаалаар тогтоосон ээлжийн амралтын хугацаа дуусаагүй байхад захирлын тушаал шийдвэргүйгээр ажиллуулж цалинжуулсан ба 10,249.9 мянган төгрөгийг олгожээ.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6-д "Харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. "Нэр бүхий 3 ажилтанд холбогдох журам зөрчин 1,618.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг олгосон.

Энэ нь "ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ""Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам""-ын Хоёр "Нэмэгдэл хөлс тооцох аргачлал"-ын 3 "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. Нэр бүхий 4 ажилтанд холбогдох албан тушаалтны тушаал шийдвэргүй буюу шийдвэрээс зөрүүтэйгээр ур чадварын нэмэгдэл 590.8 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх", "ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2 "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.4. Хууль, журам зөрчин хавсран гүйцэтгэж буй албан тушаалын цалин (ТҮ-7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан)-гаас бус үндсэн орон тооны цалин (ТҮЭМ-4-Резидент эмчээс бусад-1)-гаас нэмэгдэл тооцоноос нэр бүхий 1 ажилтанд 130.5 мянган төгрөгийн нэмэгдэл илүү олгосон.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

3.2.1. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгоходоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 4,288.2 мянган төгрөг суутган 38,593.4 мянган төгрөгийг 66 ажилтанд олгоходоо суутган буюу ногдуулан төлөх 10,250.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, тус сургуулийн захирлын 2025.10.23-ны өдрийн Б/769 дугаар тушаалуудаар "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн "балансын урамшуулал"-ыг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ээлжийн амралттай үед цалин олгосон	1	10,249.9	1	10,249.9		
Илүү цагийн нэмэгдэл илүү тооцож олгосон	1	1,618.9	1	1,618.9		
Ур чадварын нэмэгдэл илүү тооцож олгосон	1	590.8	1	590.8		
Хавсран ажилласны нэмэгдэл илүү олгосон	1	130.5	1	130.5		
Нийгмийн даатгал дутуу тайлагнасан	1	10,250.9			1	10,250.9
Балансын урамшуулал олгосон	1	1,559.0			1	1,559.0
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>24,400.1</b>	<b>4</b>	<b>12,590.1</b>	<b>2</b>	<b>11,809.9</b>